БАТЛАВ

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

С.ЭНХБАЯР

2023 оны 8 дугаар сарын ... өдөр

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 19 ДҮГЭЭР ХОРОО, ЗАЙСАНГИЙН ГҮҮРНИЙ БАРУУН ТАЛД ЯВГАН БОЛОН ДУГУЙН ЗАМ ДАГУУХ ТОХИЖИЛТЫН АЖЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2023 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар хот

Ажлын цар хэмжээ:

Энэхүү ажил нь иргэдэд аюулгүй, тохилог орчинд амьдрах, ажиллах таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой.

Нийтийн эзэмшлийн зам талбайн засвар, тохижилт ажлыг хийж гүйцэтгэхдээ бусад ажилтай уялдуулан, тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын ажил үйлчилгээнд ямар нэгэн саад бэрхшээл гаргалгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллах.

1	Төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 08 дүгээр тогтоол. - Тохижилтын архитектур төлөвлөлтийн даалгавар МЗХ2017/05-24-1
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороо, Зайсангийн гүүрний баруун талд явган болон дугуйн зам дагуух террас. - 150 м.кв талбайгаас багагүй төлөвлөх.
3	Зориулалт хүчин чадал	- Хан-Уул дүүргийн 19 дүгээр хороо, Зайсангийн гүүрний баруун талд явган болон дугуйн зам дагуух террас. - Гүйцэтгэгч байгууллага зургийн шатанд илүү дэлгэрэнгүй талбайн судалгаа, хэмжилтийг хийж нарийвчлах.
4	Одоогийн байдал	- Бетон хавтан суулгацтай шороон далан.
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
6	Төслийн захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
7	Төсөл гүйцэтгэх байгууллага	- Барилга хот байгуулалтын Яамны сайдын тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын баримт бичиг, барилга, байгууламжийн зураг, төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл, тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах, гадна тохижилтын ажил гүйцэтгэх эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжүүд оролцох боломжтой .

8	Төсөл гүйцэтгэх үе шат	- Талбайн судалгаа, хэмжилт хийх. - Хорооны Засаг даргатай заавал зөвшилцсөний дараа ажлын тоо хэмжээг захиалагчид танилцуулах. - Загвар зураг боловсруулах /Нүүр хуудас батлагдаж магадлал хийгдсэн байх/. - Ажлын зураг боловсруулах, ажлын технологи хийх аргачлалыг тодорхой харуулсан байх. /магадлал хийгдсэн байх/. - Төсөвт өртөг /магадлал хийгдсэн байх/. - Батлагдсан зураг төсвийн дагуу ажил гүйцэтгэх.
9	Орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	- Архитектур орон зай төлөвлөлтийг тус байршлын онцлог, шаардлага, орц гарц, орчны ерөнхий төлөвлөгөөтэй тохижилтын шийдэл гаргах. **<u>Террасын талбай:</u>** - Тулаас төмөр баганыг төмрийн будгаар будах, бетонон хэсгийг тосон түрхлэг 2-3 үе түрхэж үер уснаас хамгаалах. - Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага хотын стандарт UCS1409B:2022 Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн саванд тавих ерөнхий шаардлага хотын стандарт UCS1406B:2022 мөрдөх. - Хашлага хайсыг 1.2м багагүй өндөртэй төлөвлөх. - Тулгуурын болон тавцангийн тооцоололыг маш сайн тооцоолон төлөвлөх. **<u>Бусад</u>** - Гадна гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийг орчин үеийн загвартай, эрчим хүчинд хэмнэлттэй төхөөрөмж төлөвлөх. (Явган болон дугуйн зам дагуух одоо байгаа гэрэлтүүлгээс тэжээл авах) - Амрах хэсэгт орчин үеийн хийцэлтэй сандал төлөвлөх. Сандалын дээд талд нарнаас хамгаалсан сүүдрэвч сараалжтай байх. - Одоо байгаа мод, бут, сөөгийг гэмтээхгүй байх. - Бусад тохижилтын элементийг нэмэлтээр төлөвлөн захиалагчид танилцуулах.
10	Төсөл боловсруулахад ашиглах материал	**<u>Монгол Улсын хуулиуд</u>** - Хот байгуулалтын тухай хууль - Барилгын тухай хууль - Газрын тухай хууль - Усны тухай хууль - Бусад холбогдох хууль **<u>Норм, нормативууд:</u>** - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНбД30-01-04/ - Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНбД 3.01-06-90/ - Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Бусад холбогдох норм, дүрэм
11	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	- Гадаргуугийн ус зайлуулах шийдлийг орчны байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх.

12	Эдийн засгийн тооцоо, төсөв	- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНбД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.
13	Онцгой нөхцөл	- Тохижилтын стандарт мөрдөн төлөвлөх. - Улаанбаатар хотын "Нэг хот, Нэг стандарт"-ын эмхэтгэл болох UCS стандартуудыг мөрдөж ажиллах.

- Зураг төсвийг боловсруулахдаа даалгаварт заасан нэр, зориулалтыг өөрчлөхгүйгээр төсөвт өртөгт багтаах. Төсөвт өртөг хэтэрсэн тохиолдолд эскиз зураг батлагдахгүй болно.
- Зураг төсвийн болон ажил гүйцэтгэх явцад хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийг хатуу мөрдөж ажиллах.
- Эрүүл аюулгүй, чанарын шаардлага хангасан материал сонгох /БНбД-д заасан/. Зөвшөөрөгдсөн лаборатори, гарал үүслийн, сертификаттай баталгаат материалыг ашиглах.

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНГӨНШАГАЙ

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 19 ДҮГЭЭР ХОРОО ЗАЙСАНГИЙН ГҮҮРНИЙ БАРУУН ТАЛД ЯВГАН БОЛОН ДУГУЙН ЗАМ ДАГУУХ ТЕРРАС